

ГАРЧИГ

1–3 Бодлогын нийтлэл

4–5 Зохицуулалтын мэдээ

6–7 Байр суурь

8 Тайлбар зөвлөмж

9–10 Компанийн засаглал, комплайнс

11–12 Тогтвортой санхүүжилт

13–14 Финтек ба регтек

15–23 Судлаачийн индэр

24–25 Инсуртек гэж юу вэ?

26–27 Олон улсын зах зээлийн мэдээ

28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаас Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17–ны өдөр баталж, 2022 оны 02 дугаар сарын 25–ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн нийт 10 харилцааг зохицуулсан 8 журмыг баталсан.

Монгол Улсад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн орчин бүрдсэнээр 2023 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд нийт 12 хуулийн этгээд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэлтэй байна. Эдгээр 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн платформ дээр давхардсан тоогоор нийт 912,238 хэрэглэгч бүртгэлтэй байна. Үүнээс 50.2 хувь буюу 458,205 хэрэглэгч бүртгэлтэй баталгаажуулсан бол 9.3 хувь буюу 85,312 хэрэглэгч идэвхтэй арилжаанд оролцдог.



Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн платформд нийт 211 виртуал хөрөнгө бүртгэлтэй байх бөгөөд үүнээс 170 гадаад, 41 дотоодын виртуал хөрөнгө байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах

хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан дотоодын виртуал хөрөнгө өдөрт дунджаар 128.0 сая төгрөгийн арилжаа хийж, нийт 98.1 орчим тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд зах зээлийн үнэлгээ 263.9 орчим тэрбум төгрөг байна.

Салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн 2023 оны II дугаар улирлын санхүүгийн тайланг нэгтгэн харвал нийт хөрөнгийн хэмжээ 50.6 тэрбум төгрөг, орлогын хэмжээ 2.8 тэрбум төгрөг, тайлант үеийн алдагдал 7.01 тэрбум төгрөг байна.

Үргэлжлэл 2–р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ТӨВЛӨРӨЛ

Аливаа чиг үүргийн талаарх хариуцлага, эрх мэдэл нь тухайн байгууллагын нэг нэгж юмуу, эсвэл тухайн салбарын нэг байгууллагад төвлөрөх. Төрийн бүх үйлчилгээ, эрх мэдлийг (төсөв, татвар, бодлого г.м.) засгийн газрын төв, эсвэл үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйл явц. Шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлагыг байгууллагын дээд шатанд барих.



CENTRALIZATION

Centralization is the concentration of authority or responsibility for a function in a single office within an organization or a single organization within a sector or institution. Process by which government services, power (budgeting, taxation, policy, etc.) are carried out at the central or national level of government. The retention of decision-making authority and responsibility in the upper echelons of an organization.

Эх сурвалж:

Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Үргэлжлэл 1-р нүүрт

ОЛОН УЛСЫН ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

2023 оны II дугаар улирлын байдлаар Олон улсад нийт 798 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр нийт 10,024 виртуал хөрөнгө арилжаалагддаг бөгөөд өдрийн арилжааны хэмжээ 28.1 орчим тэрбум доллар байна.

Криптовалютын 2023 оны хандлагыг харвал блокчэйн технологийн хэрэглээ нэмэгдэж, салбарын өсөлт 2022 онтой

харьцуулахад өссөн байдалтай байгаа нь криптовалютад хөрөнгө оруулах хүмүүсийн тоо болон түүгээр төлбөр тооцоонд ашиглах компаниудын тоо нэмэгдэх төлөвтэй. Бизнесүүд үйл ажиллагаагаа оновчтой болгож, зардлаа бууруулахыг эрмэлзэж байгаа тул блокчейн технологийг хэрэглээ салбар бүрт ашиглагдах хандлагатай байна.



Харин АНУ-ын Үнэт цаас, биржийн хорооноос хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор дэлхийн хамгийн том виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болох “Бинанс”-ыг хэд хэдэн үндэслэлээр шүүхэд өгснөөр криптовалютын зах зээлд томоохон үйл явдал болоод

байна. Хэрэв шүүхээс нэхэмжлэгчийн талд шийдвэр гарсан тохиолдолд криптовалютын зах зээлийн уналт үргэлжлэх хандлагатай байна. Тус үйл явдалтай зэрэгцээд “Бинанс” бирж нь Арабын Нэгдсэн Эмират Улс болон Киргиз Улсад салбараа нээж үйл ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- ◆ Монгол Улсад виртуал хөрөнгө ашиглаж үйлдсэн гэмт хэрэг 2017 онд анх бүртгэгдэж, багагүй тооны хохирол үүсэж, цаашид нэмэгдэх хандлагатай байх тул виртуал хөрөнгө, арилжаа болон бусад учирч болзошгүй эрсдэлийн талаар ойлголт, мэдлэгийг нийтэд түгээх, хяналт шалгалтын тогтолцоог улам сайжруулах, техник, технологийн шийдлийг эрэлхийлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн хууль сахиулах төрийн байгууллага болон “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран виртуал хөрөнгө ашиглаж үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулахаар төлөвлөөд байна.
- ◆ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарт шударга өрсөлдөөнийг бий болгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг Монгол Улсад бүртгэлгүй олон улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч манай оронд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж байх тул тус үйлдлийг зогсоох арга хэмжээ авах, мөн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Энэ хуульд заасны дагуу бүртгүүлээгүй этгээд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно” гэж заасны дагуу байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээг авахаар зорьж байна.
- ◆ Санхүүгийн зохицуулах хорооноос Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 15 (Шинэ технологи)-ын үнэлгээг ахиулах ажлын хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээг боловсруулах, тэдгээр эрсдэлийг удирдах, бууруулахын тулд зохих арга хэмжээ авч ажиллана. Мөн түүнчлэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулна.
- ◆ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгчдийн тоо, ханшийн мэдээлэл зэргийг өдөр бүр хянаж, зах зээлийн төлөв байдлыг ажиглах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор ажиллаж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТАЙЛАН ГАРЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсанаар нээлттэй хувьцаат компаниуд уг кодексийг дагаж мөрдөх үүргийг хүлээсэн.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 1, 2 дугаар ангиллын 68 ХК, 3 дугаар ангилалд бүртгэлтэй 40 ХК, нийт 108 ХК-ийн кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахад, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ 53.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Санхүүгийн зохицуулах хорооноос тайлангийн хариугаар компани тус бүрт зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, 6 дугаар сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр кодексийн хэрэгжилт дунджаар 12.7 хувиар өслөө.

Ингэснээр компанийн засаглалын чанар буюу кодексийн хэрэгжилтийн тайлангийн үр дүнд суурилсан зэрэглэл тогтоох үнэлгээ гарах юм.

Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлэх, үнэлгээний нэгдсэн тайлан, судалгаа гаргах болон засаглалын зэрэглэл тогтоох нь компанийн засаглалын чиг хандлага, эрсдэлийг тодорхойлох, засаглалаар тэргүүлэгчдийг тодруулах, нөгөө талаар компанид өөрийн засаглалын түвшинг бусадтай харьцуулах, сайжруулахад нь зориулсан сайн жишгийг бий болгох, эрсдэлийн дүн шинжилгээ хийхэд шаардлагатай засаглалын үзүүлэлтийг бий болгосноор хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад эергээр нөлөөлөх зэрэг ач холбогдолтой.

Тус Хорооноос кодексийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн тайланг тогтмол гаргах ба судалгааны үр дүнг компанийн засаглалын зохицуулалтын орчныг боловсронгуй болгоход дүн шинжилгээ хийх, олон нийтэд мэдээлэл өгөхөд зориулж ашиглана.

“АЗИЙН БАТЛАН ДААЛТТАЙ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО”-НЫ 35 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛОВ



“Азийн батлан даалттай зээлийг дэмжигч байгууллагуудын холбоо (ACSLC)”-ны “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ ЦОГЦЛООХ НЬ” сэдэвт олон улсын чуулга уулзалтын 2 дахь өдрийн хуралдааныг Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал нээж үг хэлсэн бөгөөд тэрээр Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй



ажлуудаас гадна Санхүүгийн зохицуулах хорооны салбар бүрийн бодлогын хүрээнд хийгдсэн томоохон ажлууд болох биржийн болон биржийн бус зах зээл дээр ногоон бонд гаргах эрх зүйн орчныг бүрдүүлсэн, “Байгаль орчин нийгэм, засаглал (БОНЗ), Тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийг гаргасан, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлагын журамд “ногоон даатгал”-ыг тодорхойлж, даатгалын компаниуд энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах эрхзүйн орчныг бүрдүүлсэн, мөн “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг баталсан зэргийг онцлон дурдлаа. Тэрээр “Ногоон зээл, ногоон бонд гаргах хүсэлтэй боловч барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэр эрхлэгчид нэлээдгүй байгаа бөгөөд цаашид Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тогтвортой, ногоон санхүүжилтийг дэмжих зорилгоор ногоон зээл, ногоон бонд зэрэг бүтээгдэхүүнүүдэд батлан даалт гаргуулах чиглэлд холбогдох дотоодын болон гадаадын батлан даалтын сангуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.” хэмээлээ.

Тус чуулга уулзалтад Азийн батлан даалттай зээлийг дэмжигч байгууллагуудын холбооны гишүүд болох Япон, БНСУ, Тайланд, Индонез зэрэг Ази тивийн 14 улсын 19 гишүүн байгууллага болон Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Азийн хөгжлийн банк зэрэг санхүү, эдийн засгийн байгууллагуудын нийт 150 гаруй зочид, төлөөлөгчид оролцов.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн ээлжит хурал боллоо. Хуралдаанаар хөрөнгө оруулалтын сангуудын хөгжил ба тулгамдаж буй асуудлууд, арилжаа эрхлэх байгууллагын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон хөрөнгийн зах зээл дээрх шимтгэл, хураамжийн талаар хэлэлцлээ.

Аливаа улсын хөрөнгийн зах зээлийн хөгжилд мэргэжлийн хөрөнгө оруулагчид, тэр дундаа хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сангуудын оролцоо ихээхэн чухал байдаг бөгөөд Монгол Улсын хувьд анхны хамтын хөрөнгө оруулалтын сангууд үүсээд өдгөө 2 жил болж байна. Энэ хугацаанд эдгээр хамтын сангуудаас хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулахад тулгарч буй бэрхшээл, тухайлбал хөрөнгө оруулалт хийхэд тавигддаг хязгаарлалт, мөн хуулиар хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагааны орлогыг энэ жилээс эхлэн татвараас чөлөөлсөн хэдий ч хэрхэн чөлөөлөх процесс нь тодорхойгүй байгаа зэрэг асуудлууд байгаа талаар хэлэлцэж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг дүрэм, журамд оруулах талаар бодлогын зөвлөлөөс зөвлөмж гаргахаар шийдвэрлэлээ. Түүнчлэн татварын зохицуулалтын орчин, дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийн асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар тогтлоо.

Хөрөнгө оруулалтын сан нь гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг дотоодын зах зээл рүү татах чухал сувгуудын нэг болдог. Хөрөнгө оруулалтын сангууд идэвхжиж байгаа энэ цаг үед жижиг хөрөнгө оруулагчид хамтын хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компаниар дамжуулан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ авч, хөрөнгө оруулалт хийснээр урт хугацаанд хөрөнгөө өсгөх, өгөөж хүртэх, ногдол ашиг авах боломж бүрдэнэ.

Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн даргаар Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, зөвлөлийн гишүүдээр Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэл, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Гантулга, салбарын мэргэжлийн холбоод болон компаниудын удирдлагууд, МУИС, СЭЗИС-ийн төлөөлөл тус тус ажиллаж байна.

БАЙР СУУРЬ

МОНГОЛ УЛСЫН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтсийн референт Б.Батмөнхтэй виртуал хөрөнгийн зах зээлийн талаар ярилцлаа



Компани болон хувь хүн койн гаргахад шаардлагатай шалгуур, дүрэм, журам байгаа юу?

Төрөөс болон Санхүүгийн зохицуулах хорооноос койн гаргагчдад тавьж буй холбогдох шаардлага гэж байхгүй. Харин төрөөс хийж буй зохицуулалт нь тухайн койн, токеныг арилжаалах биржид ямар шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах вэ гэдгийг нь тогтоож өгдөг. Биржүүд ямар виртуал хөрөнгийг өөрийн платформ дээр арилжаалах, шинээр жагсаалтдаа оруулах, хасах журмаа баталж, ирүүлэх шаардлагатай байдаг. Энэ журамд нь хэд хэдэн шаардлага тавьдаг. Өөрөөр хэлбэл, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу тухайн койныг гаргагчдад хяналт тавих, мэдээллийн баримт бичиг /white paper/-ийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавих гэх мэт шаардлагуудыг тухайн байгууллага дотоод журмаараа зохицуулдаг юм.

Цагдаагийн байгууллагаас койн гаргасан компани, хувь хүмүүсийг мөнгө угаасан хэргээр шалгаж байгаа талаар мэдээлсэн. Санхүүгийн зохицуулах хороо койн гаргагчдад хяналт тавих боломж байдаг уу. Санхүүгийн зохицуулах хороо мөнгө угаах гэмт хэргийн эсрэг ямар байдлаар оролцож байна вэ?

Санхүүгийн зохицуулах хороо мөнгө угаах гэмт хэргтэй тэмцэх үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх байдлаар оролцдог. Манай байгууллага хянаж, мөрдөн шалгах эрхгүй. Тиймээс ямар койноор мөнгө угааж байна гэдэгт хяналт тавихаас илүүтэйгээр зөвшөөрөлтэй байгууллагад мөнгө угаах гэмт хэргээс сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг гэж ойлгох хэрэгтэй. Тухайлбал, гарын авлага тогтмол бэлтгэж гаргах, мөнгө угаахын эсрэг улирал бүр зохицуулагч

байгууллагуудад бүгдэд нь хэрэгжүүлж байгаа. Мөн газар дээрх болон зайны хяналт, шалгалт хийж байна. Холбогдох сэдэв бүхий сургалтыг явуулах гэх мэт урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулдаг.

Дэлхийн крипто зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ?

Манай улсын крипто зах зээлийн зохицуулалтыг дэлхийн бусад улс орноос хоцорсон гэж хардаг. Учир нь виртуал хөрөнгө 2008 оноос хойш маш хурдацтай хөгжсөн. Ихэнх улс орнууд өөр өөрийн гэсэн онцлог арга хэмжээг авсан байдаг. Зарим нь Үнэт цаасны тухай хуулиар зохицуулдаг бол нөгөө хэсэг нь тухайлсан Виртуал хөрөнгийн тухай хуулиар зохицуулж байх жишээтэй. Өөр нэг хэсэг нь виртуал хөрөнгийг хориглосон. Нийт есөн орон хориглосон байдаг. Харин 54 улс орон зөвшөөрсөн. Олон улсад криптовалютын өсөлтүүд нэлээдгүй ажиглагдсан, үүний хажуугаар саар мэдээ ч гарч байна. Учир нь 2017 оноос хойш криптовалютаар дамжуулж мөнгө угаах тохиолдол дэлхий дахинаа нэмэгдсэн. Сүүлийн гурван жилийг тоймлоод харвал 20 гаруй тэрбум ам.доллар угаагдсан гэх мэргэжилтнүүдийн тооцоолол бий. Урьдчилан сэргийлэхийн тулд ФАТФ буюу Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага зөвлөмждөө шинэчлэлт оруулж, улс орнуудад хяналт шалгалт хийх, үүнтэй холбоотойгоор хууль тогтоомжид бодлогын өөрчлөлт оруулах, зохицуулагч байгууллагыг тодорхойлох гэх мэт шинэ зохицуулалтыг бий болгосон. Үүний дагуу 2018 оноос улс орнуудад хүлээн зөвшөөрөх эсвэл хориглох хоёр сонголтыг өгсөн юм. Манай улс бусад улс орны адил зөвшөөрснөөр эрх зүйн баримт бичгийг боловсруулж, үйл ажиллагаа явуулж байна.

Крипто зах зээлд гарсан өөрчлөлтүүдээс дурдвал?

Ойрын хугацаанд цар тахлаас үүдэлтэйгээр олон өөрчлөлт гарсан. Нэгдүгээрт, маш их хөөсрөлт бий болсон. Биткойны ханшийг дагаад олон криптовалютын үнэлгээ өссөн. Одоогоор биткойны ханшийг дагаж криптовалют унаж байна. Тухайн виртуал хөрөнгийг 100 хувь баталгаатай, ашиг өгөөжөө үргэлж өгдөг, үнээ тогтвортой хадгалдаг гэх нь хийсвэр ойлголт юм.

Хийсвэр ийм зүйлийн үнэ цэн нь юу вэ?

Криптовалют блокчэйн технологийн нэгээхэн хэсэг. Цаашид блокчэйн технологи өсөлттэй байна гэж бид харж байна. Үүний хэрэглэгдэхүүн нэг хэсэгт криптовалют зайлшгүй орно. Тиймээс тухайн виртуал хөрөнгөд ямар үйл ажиллагаа, хөрөнгө байна вэ гэдэг нь чухал юм.

Өнгөрсөн хугацаанд манай улсад ажиглагдсан зүйл бол нэр хүндээ ашиглаж олон хүнээс хөрөнгө босгож, үйл ажиллагаагаа эхлүүлсэн үйлдлүүд билээ. Тэгэхээр ардаа үнэ цэнийг бий болгож байдаг, тухайн виртуал хөрөнгө нь ямарваа нэгэн байдлаар хэрэглэгдэх нөхцөлтэй байснаар илүү үнэ цэнтэй байх болов уу.

Хорооноос зөвхөн койн гаргагчдын бүртгэлийг хийдэг гэж байна. Тэгэхээр бүртгэл хийхдээ тухайн компанийн үнэ цэнийг үнэлсэн үнэлгээ гэх зүйлийг хийдэг үү?

Үнэлгээ гэх зүйл одоохондоо байхгүй. Тухайн байгууллагуудын крипто зах зээлд хэр их хэмжээний хөрөнгөөр арилжаа хийдэг вэ гэх судалгааг л хийж байна. Крипто зах зээлд хэн арилжаа хийсэн нь ил тод харагдахгүй. Үүнийг ил тод болгох боломж байдаг юм болов уу? Блокчэйн хийж буй гүйлгээ зарим тохиолдолд ил тод байдаг. Ингэхдээ ямар блокчэйн ашиглаж байна вэ гэдгээс хамаарна. Монголд ихэвчлэн “Binance smart chain”-ийг ашиглаж, токениудыг боловсруулж гаргадаг. Виртуал хөрөнгийн зах зээл уламжлалт зах зээлээс ялгарах нь хэн оролцож байгаа, хэн рүү шилжүүлж байгаа нь мэдэгдэхгүй. Үүнийг нэг төрлийн эрсдэл хэмээн тооцож байгаа юм. Тиймээс олон улсын байгууллагууд “Travel rule” гэх нэр томъёог гаргасан. Хэн оролцож, хэнээс шилжүүлж байгаа гэдгийг ил тод болгох хэрэгтэй хэмээн үзсэн. Үүний дагуу манай улс холбогдох ажлуудыг цаашдаа хийж явна.

Энэ зах зээл бүхэлдээ эрсдэлтэй шүү дээ. Эрсдэлийн үнэлгээ гэх зүйл байна уу?

Эрсдэлийн үнэлгээг 2021–2022 онд жил дамнаж хийсэн. Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, хууль хүчний байгууллагууд хамтарч эрсдэлийн үнэлгээг хийж холбогдох дүгнэлтүүд гарсан. Дүгнэлтээс нь танилцууля. Тухайн салбарын эрсдэл нь дундаж түвшинтэй байна гэж гарсан. Эрсдэлийг бууруулж байгаа зүйл нь эрх зүйн орчин болон зохицуулагч байгууллагуудтай болсон явдал юм. Харин эрсдэлтэй байлгаж буй зүйл нь нэгдүгээрт, тухайн виртуал хөрөнгийн зах зээл “төрөлхийн” эрсдэлтэй учраас энэ салбараар дамжуулж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг бүрэлдэх боломжтой. Шалтгаан нь өмнө ярилцсан нэрээ нууцалсан арилжаа хийдэг учраас гэмт хэрэг үйлдэгчдийн бай болдог. Хоёрдугаарт, хил дамнуулсан гүйлгээ хийх боломжтой байдал юм. Гуравдугаарт, дэлхий даяар “Travel rule” буюу аяллын дүрмийг эцэслэж шийдээгүй байгаа. Зөвхөн төвлөрсөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд хэрэгжих боломжтой. Хэрэв төвлөрсөн бус руу энэ мөнгө шилжвэл харагдах боломжгүй тул эрсдэлийг нэмэгдүүлдэг. Дээрх асуудлуудыг үнэлээд, Монгол Улсын түвшинд крипто зах зээлийн эрсдэл дундаж түвшинд байна хэмээн харсан.

Дундаж түвшнээ задлаад яривал?

Дундаж түвшнийг задлаад харвал аюул заналхийлэл, эмзэг байдлын үнэлгээ гарч ирдэг. Аюул заналхийлэл 49 хувьтай буюу дундаж түвшинтэй. Харин эмзэг байдлын хувьд 61 хувьтай буюу дунджаас харьцангуй дээш хувьтай.

Эмзэг байдал гэдэг нь манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаахыг санхүүжүүлэх болон бусад гэмт хэрэгт тухайн салбараар дамжуулан хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлөөс урьдчилан сэргийлэх ойлголт

тодорхой хэмжээнд байна гэсэн үг. Аюул заналхийлэл гэдэг нь зах зээлд ирэх аюул их байх боломжтой гэсэн үг. Тэгэхээр дундаж түвшний буюу 49 хувийн гэмт хэргийн аюул заналхийлэл энэ салбарт байж болзошгүй гэж тооцоолсон хэрэг. Энэ нь төвлөрсөн бус биржээс төвлөрсөн бирж рүү үл таних койн, токен ашиглаж, цаашдаа мөнгө угаах эрсдэлтэй тул тооцоолсон.

Хуулийн дагуу бол хувь хүн өөрөө койн гаргах боломжгүй байх аа?

Тийм ээ. Зөвхөн бүртгэлтэй компаниуд дээр шинээр койн гарах, олон нийтээс хөрөнгө татахаар хуульд заасан.

Энэ заалтаар бол ICO буюу хувь хүний дансаар мөнгө цуглуулж, өөрөө вэбсайт хөгжүүлж, олон нийтээс мөнгө татах үйлдлийг хуулиар хориглож, зөвхөн бүртгэлээ хийлгэсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд IEO хэлбэрээр гарах боломжтой гэсэн үг.

ICO, IPO, IEO гэх мэт олон төрлийн нэршил бий. Эдгээрийн ялгаа нь юу вэ. Уншигчдад маань тайлбарлаж өгөхгүй юү?

Хөрөнгийн зах зээлд байх IPO-тэй төсөөтэй нэршлүүд нэлээдгүй гарсан.

Нэгдүгээрт, ICO гэдэг нь Хөрөнгийн бирж дээр бус хувь хүн өөрөө койн гаргах явдал юм. Ингэхдээ өөрийн дансыг байршуулдаг бөгөөд тэнд ямар нэгэн байдлаар арилжаа хийхгүй. Зөвхөн хөрөнгө босгох үйл ажиллагаа юм. Тухайлбал, IZ койн гэх мэт. Энэ нь маш эрсдэлтэй байдаг. Тухайлбал, Япон улс 2009, 2010 онд 100 гаруй ICO хийсний улмаас залилан ихээр бий болсон гашуун туршлага байдаг учраас хорьсон.

Хоёрдугаарт, IEO гэдэг нь анхдагч болон хоёрдогч арилжаанд нэг талбарт байна гэсэн үг. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн биржээр гарах бөгөөд тухайн биржийн шалгуурыг хангасан тохиолдолд авах боломжтой юм. Өмнөхөөс ялгаатай нь хувь хүн бус компанийн биржтэй холбогдоно.

Гуравдугаарт, IDO гэж ойлголт бий. Төвлөрсөн бус биржээр дамжуулж олон нийтэд гарах койн юм. Төвлөрсөн бус зах зээлийг манай улс уулиар хориглосон.

Дөрөвдүгээрт, IPO гэдэг нь компани хувьцаагаа олон нийтэд нээлттэйгээр санал болгож, хөрөнгө оруулагч татах явдал юм.

Тавдугаарт, STO гэх ойлголт бий. Энэ нь үнэт цаасаар баталгаажсан койны төрөл юм. Гэвч манай улсад хуулиар хориглосон. Виртуал хөрөнгө гэдгийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар хориглосон. Энэ тодорхойлолтоор нэгдүгээрт, үнэт цаасны зах зээлийн ямар нэгэн харилцаанд оролцохгүй байх, хоёрдугаарт, Монголбанкны цахим мөнгөний харилцаанд оролцохгүй гэж заасан. Түүнээс бусад хөрөнгө оруулалтын шинжтэй эдийн бус хөрөнгийг виртуал хөрөнгө хэмээн тодорхойлдог. Тиймээс STO ч манай улсад хориотой.

Шинээр койн гаргахаар хандсан компани байгаа юү?

Одоогоор мэдэгдсэн хуулийн этгээд байхгүй. Хуулийн дагуу шинээр виртуал хөрөнгө гаргахаар бол Виртуал хөрөнгөөр үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.5-д заасанчлан нийтээс шинэ токены хөрөнгө оруулалт татах зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Үүнийг хийлгэсэн компаниуд виртуал хөрөнгийг шинээр IEO хэлбэрээр гаргаж байгаа бол Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх үүрэгтэй байдаг.

ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

“ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ”-ЫН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-д 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор шинэчлэн баталж арилжаа эрхлэгчдээс тайлан мэдээ ирүүлэх болон түүнтэй холбоотой холбогдох өөрчлөлтийг орууллаа.

Тус журмаар арилжаа эрхлэгчээс тайлан, мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд тайлагнах, мөн эртний эдлэлийн арилжаа эрхлэгчид тухайлсан маягтын дагуу арилжааны мэдээг гаргах, үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид арилжаа хийсэн тухай бүр татварын цахим төлбөрийн баримтын системд мэдээллийг илгээх, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь үнэт металл олборлосон аймаг, сумын мэдээллийг ирүүлэх зэрэг зохицуулалтыг журамлан оруулсан.

“ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ”-ЫН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 181 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-д 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 235 дугаар тогтоолоор шинэчлэн баталж холбогдох өөрчлөлтийг орууллаа.

Тус журмаар зуучлалын мэдээний загварыг сайжруулж, статистик тоо мэдээг баяжуулснаар зайны хяналт, шалгалтыг хялбаршуулсан бөгөөд санхүүгийн тайланг улирал бүр Хороонд тайлагнахаар холбогдох зохицуулалтыг журамлан оруулсан.

“ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 174 дүгээр тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ыг баталж, 2023 оны хагас жилийн байдлаар нийт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч холбогдох зөвшөөрлийг авсан байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны онцлог нь бүхэлдээ цахимаар иргэдэд виртуал хөрөнгийн арилжаанд оролцох боломжийг олгодог бөгөөд бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл, тэдгээрийн хөрөнгийг аюулгүй, найдвартай хадгалах үүрэгтэй тул мэдээлэл технологийн аюулгүй байдлын стандартуудыг үйл ажиллагаандаа зайлшгүй нэвтрүүлж, хөндлөнгийн гуравдагч этгээдээр баталгаажуулсан байх шаардлагыг тусгасан. Ингэхдээ тус журмын гуравдугаар хавсралтад заасан MNS ISO/IEC 27001 (Мэдээллийн технологи: Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-Шаардлага) стандартыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэхээс өмнө өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд үлдсэн нэр бүхий 10 стандартын хэрэгжилтийг 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хангаж ажиллах үүргийг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 174 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт зааснаар үүрэг болгосон.

Гэвч дээрх нэр бүхий 10 стандартыг хэрэгжүүлсэн эсэх талаарх албан ёсны дүгнэлт тодорхойлолт гардаггүй учир Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 253 дугаар тогтоолоор дээрх дүгнэлт тодорхойлолт гаргуулах шаардлагыг өөрчлөн хүсэлт гаргагчид илүү ойлгомжтой болгон холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗҮГЭЭС ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ИТГЭЛИЙГ ХЭРХЭН ТӨЛӨВШҮҮЛЭХ ВЭ? /ҮРГЭЛЖЛЭЛ/

Итгэлцлийн менежментийг идэвхтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хооронд итгэлцэл үүсгэх, түүнийг бэхжүүлэхэд юу саад болж байна вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 46.0 хувь нь ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үр дүнг хэрхэн тооцох нь тодорхойгүй, 21.0 хувь нь итгэлцлийг удирдах хариуцсан этгээд байдаггүйг онцолсон бол судалгаанд оролцогчдын гуравны нэг нь итгэлцлийг бий болгох, сэргээхэд ямар ч саад бэрхшээл байхгүй гэж хариулсан.

Lack of process steps and measurement protocols top the list of leadership challenges

What barriers does your organization face in building or rebuilding stakeholder trust? (Multiple choice)



Note: N=177.
Source: Deloitte Global Boardroom Program Trust Survey.

“Рио Тинто групп” компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Саймон Хенри хэлэхдээ: “Бид өөрчлөгдөж буй хүлээлттэй зэрэгцэн ажиллах хэрэгтэй. Өчигдрийн хувьд хангалттай сайн байсан зүйл маргааш хангалтгүй болж магадгүй. Хэрэв энэ өөрчлөлтийг удирдаж, түүнд нийцүүлэхгүй бол бидний ажил үр дүнгүй болох ба эцсийн дүндээ энэ нь нэр хүнд, өөрийгөө үнэлэх үнэлэмж, зорилгод нөлөөлнө” гэв.

Зарим тохиолдолд, үл мэдэгдэх зүйл буюу далд буй зүйлээс айх айдас нь итгэлийг нэмэгдүүлэхэд саад болж болзошгүй бөгөөд судалгаанд оролцогчдын 11.0 хувь нь далд байсан асуудал ил болж магадгүй тул санаа зовж байна гэж хариулжээ. “Жейкобс” компанийн стратеги, засаглалын хөгжлийн захирал Клаудия Харамильогийн тэмдэглэснээр “Итгэл нь айдастай байж болох ч бид түүнийг даван туулах ёстой” гэжээ. Мөн тэрээр “Бид хүмүүсийг шинээр элсүүлж, авьяас чадварыг нь хөгжүүлэх явцдаа тэдэнд шинэ зүйл туршиж, хэрэгжүүлж үзэх боломжийг олгодог ч бүтэлгүйтлээс айдаг. “Жейкобс”-ийн үндсэн үнэт зүйлсийн нэг бол хүлээн зөвшөөрөхийг уриалах явдал юм. Бодит байдал дээр юу тохиолдохыг мэдэхгүй ч, бид үл мэдэгдэх зүйлтэй нүүр тулгарах бүрт цаашид улам бүр туршлагатай болно” хэмээжээ.

Итгэлийг олж, хэмжих найдвартай суурийг бий болгох

Өмнөх судалгаанаас харахад, байгууллагууд оролцогч талууд хоорондын итгэлцлийг үйл ажиллагааны гүйцэтгэлийн чухал үзүүлэлт болгох, түүнийг хэрхэн хэмжих талаар ямар нэг зүйл хийхийг огт оролдож байгаагүй нь харагджээ. Тухайлбал, судалгаанд хамрагдагсдын талаас бага хувь нь оролцогч талууд хоорондын итгэлцлийг хэмждэг бол үлдсэн 45.0 хувь нь энэхүү итгэл үнэмшлийг хэмждэггүй, 12.0 хувь нь энэ талаар ямар нэгэн арга хэмжээ авдаг эсэхийг мэдэхгүй гэж хариулжээ.

Делойт Консалтингийн ерөнхий зөвлөх, байгууллагын итгэлцлийн удирдагч Майклц Бондарийн хэлснээр “Оролцогч талууд хоорондын итгэлцлийг хэмжих нь байгууллагуудын үндсэн үүрэг бус, энэ асуулгын үр дүн ч гайхмаар зүйл биш юм. Тэрээр үргэлжлүүлэн, гэхдээ итгэлцлийг хэмжихэд маш олон аргачлалууд бий. Хүний сэтгэл хөдлөлийг илүү сайн ойлгохын тулд үйлчлүүлэгчид болон ажиллагсдын харилцаанд дүн шинжилгээг ашигладаг тактикийн дуут аргачлалыг ашиглаж байгаа бол зарим байгууллагууд бүтээгдэхүүний чанарыг ажилчид, үйлчлүүлэгчид болон бусад оролцогч талуудын зүгээс найдвартай гэж үзэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд 360 хэмийн зохион байгуулалтын үнэлгээ хийх стратегийн аргачлалыг ашиглаж байгаа талаар дурджээ.


Байгууллагын итгэлцлийг хэмжих зорилгоор шинэ цогц мэдээлэл цуглуулах нарийн төвөгтэй үйл явц нь эсрэгээрээ бэрхшээл үүсгэдэг, нөгөөтээгүүр энэ нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ биш аж. Харвардын Бизнесийн Сургуулийн профессор Сандра Сучер, байгууллагууд оролцогч талуудын итгэлийг илүү сайн ойлгохын тулд өөрийн хэрэглэж буй программуудыг хэрхэн ашиглаж болохыг дурджээ. Жишээлбэл, хэрэглэгчийн зүгээс компанид бага оноо өгснийг ойлгохын тулд утсаар холбогддог Net Promoter Score программ. Мөн ажилтан ажлаас гарах үед ярилцлагад оруулж, ажлаас гарах болсон нөхцөл, шалтгааныг тодруулан дүн шинжилгээ хийх боломжтой юм. Байгууллагууд оролцогч талууд хоорондын итгэлцлийн талаарх ойлголтоо болохын тулд өөрт байгаа программууд болон өгөгдлийг нарийн судлах шаардлагатай талаар тэрээр зөвлөжээ.

Судалгаанд оролцогчдоос ирэх зургаан сарын хугацаанд оролцогч талуудын итгэлийг олж авахын тулд байгууллагын зүгээс ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ гэсэн асуултад 58.0 хувь нь байнгын, тууштай, бодитой итгэлцлийн үнэлгээ, хэмжилт хийж, оролцогч талуудын итгэлцлийн талаар тодорхой тоон үзүүлэлттэй болох гэж буй талаараа дурджээ. Ихэнх байгууллагуудын хувьд дараагийн авах арга хэмжээ нь итгэл төрүүлэх бат бөх суурийг бий болгох явдал юм.

ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх нь (83.0%) зургаан сарын дотор итгэлцлийн талаар арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж, бараг тал хувь нь (45.0%) нь байгууллагын хэмжээнд итгэлцлийн цогц, үнэн зөв тодорхойлолт, хүрээг боловсруулах шаардлагатай, 42.0 хувь нь ойрын ирээдүйд ТУЗ-ийн үйл ажиллагааны хөтөлбөрт итгэлцлийн асуудлыг оруулах бодолтой байгаагаа тэмдэглэжээ. Харин 17.0 хувь буюу таван компани тутмын нэг нь аль хэдийн итгэлцлийг бий болгосон тул цаашид ямарваа нэгэн арга хэмжээ авах шаардлагагүй гэж үзжээ.

Measuring and developing frameworks around trust top near-term priorities

What actions does your organization need to take in the next six months to earn stakeholder trust? (Multiple choice)



Оролцогч талуудын итгэлцлийг хадгалах, бэхжүүлэх хүчин чармайлтаа эрчимжүүлэхээр төлөвлөж байгаагаа санал асуулгад мөн дурдацгааж байна. Сүчериин хэлснээр, гол зүйл нь компаниуд бэрхшээл тулгарсан ч түүнтэй тэмцсээр байх ёстой, итгэлийг нэгэнт алдсан бол хэзээ ч сэргээж чадахгүй гэдэг боловч нэгэнт оролцогч талуудын итгэл алдарсан ч түүнийг амжилттай даван туулж, сайн ажиллан хөл дээрээ боссон компаниуд ч бий ажээ.

Итгэлцлийн тухай ТУЗ-ийн хэлэлцэх таван сэдэв

- ◆ Итгэлцлийг тодорхойлох. (Оролцогч талуудтай харилцах харилцаанд итгэлцлийг тодорхойлох)
- ◆ Итгэлцлийн удирдахад ТУЗ-ийн үүргийг тодорхойлох. (Оролцогч талуудын итгэлийг олж авахад ТУЗ-ийн үүрэг хариуцлага юу вэ, энэ нь бусад чиг үүргээс юугаараа ялгаатай вэ?)
- ◆ Итгэлийг хэмжих. (Оролцогч талуудын итгэлийг хэмжихэд ямар хэмжүүр ашиглах вэ? Эдгээр хэмжигдэхүүнүүдийн чанар, нарийвчлалыг сайжруулахын тулд бид юу хийж чадах вэ?)
- ◆ Тэргүүлэх чиглэлүүдээ үнэлэх, өөрчлөлтийг урьдчилан таамаглах. (Итгэлцлийг бий болгоход одоогийн тэргүүлэх чиглэлүүд, эдгээр нь дараагийн хэдэн жилд хэрхэн өөрчлөгдөх вэ?)
- ◆ БОНЗ-ын стратегийн итгэлцлийн ахиц дэвшилд үзүүлэх үр нөлөөг үнэлэх. (Тогтвортой байдлын талаарх бидний амлалт, БОНЗ-ын өргөн хүрээг хамарсан хүчин зүйлүүд нь оролцогч талуудын итгэлийг бий болгохыг хэр дэмждэг вэ?)

Эх сурвалж: www.deloitte.com

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

КАРБОН ЗАХ ЗЭЭЛ /ҮРГЭЛЖЛЭЛ/

Тогтвортой санхүүжилт булангийн өмнөх дугааруудад карбон зах зээлийн талаар мэдээлэл хүргэсэн бол энэ удаад карбон зах зээлийн үнэ цэнийн тухай, хөрөнгө оруулагчдын сонирхлын талаар хүргэхээр мэдээлэл бэлтгэлээ.

Хууль ёсны дагуу карбон зах зээл нь зохицуулалттай байдаг ба

карбон кредитийн үнэлгээ нь өөрөө баталгаатай байдаг. Харин сайн дурын карбон зах зээл зохицуулалтгүй ба карбон оффсетэд гуравдагч тал үнэлгээ хийдэг тул үнэлгээ бүхэн харилцан адилгүй байдаг. Сайн дурын карбон зах зээл дэх карбон оффсетын үнэлгээг Засгийн газраас баталгаажуулдаггүйбайдаг байна.


Нүүрстөрөгчийн нөхөн төлбөрт юу ордог вэ? Тухайн хөтөлбөрт түгжигдсэн нүүрстөрөгчийн тонныг хэн тооцдог вэ? Нүүрстөрөгчийн ялгаруулалтын бууралтыг хэн хэмждэг вэ?

Ухаалаг нүүрстөрөгчийн оффсет үйлчилгээ үзүүлэгч нь оффсет зах зээл нь өөрийгөө баталгаажуулах эцсийн хэрэгсэл болох алтан боломж гэдгийг ойлгодог. Хамгийн сайн баталгаажуулалтын процесстой гэж хэлж чадах аливаа компани ирэх жилүүдэд хурдацтай хөгжиж буй оффсет зах зээлийг тэргүүлэх байр сууриа эзэлж чадна.

Тогтвортой хөгжлийн үр өгөөжийг бий болгоход нүүрстөрөгчийн давхар ислийг нотолж чадсан компанид давуу тал бий болж хүлэмжийн хийн ялгаруулалтын бууралтыг тодорхой харуулж чадсан хэн бүхэн энэхүү амжилтаа ашиглан төсөлдөө илүү олон хөрөнгө оруулагчдыг татах боломжтой болно.

Сайн дурын нүүрстөрөгчийн зах зээлд илүү сайн баталгаажуулалт нь бодит үр дүнд хүргэдэг. Байгаль орчны хор хөнөөлийг улам бүр мэддэг болсон дэлхий дахинд илэрхий үр дүн нь нүүрстөрөгчийн давхар ислийн борлуулалтыг нэмэгдүүлэх явдал юм

Үүнийг хийхийг оролдсон компанийн нэг жишээ бол Верра юм. Верра өөрийгөө нүүрстөрөгчийн давхар ислийн худалдагч биш,



харин нүүрстөрөгчийг найдвартай стандартаар хангадаг компани гэдгээрээ зах зээлд танигдсан. Верра өрсөлдөгчдөөс ялгарах зүйл бол тэдний дотоод оффсет баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх хүчин чармайлт юм.

Веррагийн хувьд энэ нь Веррагийн зөвшөөрөгдсөн аливаа оффсет хөтөлбөрийг дагаж мөрдөх аудитуудын сүлжээг сонгон шалгаруулах, сургах, хадгалах гэсэн үг юм. Энэ

нь нэг тонн нүүрстөрөгчийг нөхөх нь бодит тонн нүүрстөрөгчийн хаягдлыг баталгаажуулахыг хичээж байгаа төслийн дотоод нөхөн төлбөрийн баталгаажуулалт юм. Үүнийг хийхэд хэлэхэд хялбар бөгөөд өргөн сүлжээ шаардлагатай.

Энэ нь зах зээлд сөргөөр нөлөөлж байгаа мэт санагдах ч эцсийн үгийг хэрэглэгчид үргэлж хэлэх болно. Нүүрстөрөгчийг нөхөх төслүүдийн хоорондын ялгаа шууд харагдахгүй байж болох ч зах зээл өсөхийн хэрээр нэр хүнд дээр тулгуурлан нөхөн төлбөрийг сонгоход хялбар байх болно. Нүүрстөрөгчийн давхар ислийн стандартыг засгийн газраас гаргах шаардлагагүй.

Түүнчлэн Хятад улс 5 жилийн өмнө орхигдсон нүүрстөрөгчийн сайн дурын зээлийн төлөвлөгөө болох Хятадын Баталгаажсан ялгаралтыг бууруулах (CCER) системийг дахин эхлүүлэхээр бэлдэж байна. Энэ нь Хятадын нүүрстөрөгчийн хийн худалдааны шинэ зах зээл болох Үндэсний ялгаруулалтын худалдааны схемийг (ETS) дагаж мөрдөх эхний хугацаа дууссантай давхацсан юм.

CCER нь нүүрстөрөгчийн хийн зардлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх чухал механизм бөгөөд нүүрстөрөгчийн зардлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний зорилтод хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж тооцоолж байна.

CCER-ийг компаниуд сайн дурын үндсэн дээр явуулдаг бөгөөд Хятадын Засгийн газраас баталгаажуулдаг. Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, хог хаягдлаас эрчим хүч гаргах санаачилга зэрэг төслүүд, ойн аж ахуйн төслүүд үр өгөөжөө өгөх болно.

Нүүрстөрөгчийн ялгаруулагч нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр гэх мэт CCER эзэмшигчдэд зээлийн төлбөрийг төлдөг.

Эдгээр сайн дурын CCER кредитийг дагаж мөрдөх ETS-ийн нэг хэсэг болох компаниудын ялгарлыг нөхөхөд ашиглаж болно. Нүүрстөрөгчийн зээлийг Хятадын ялгаруулалтын тэтгэмжийн (CEAs) дутагдлыг нөхөх, эсвэл үндэсний ЭЕШ-д оролцож буй компаниуд хөтөлбөрийн дагуу худалдан авах эсвэл арилжаалах боломжтой зээлийг нөхөхөд ашиглаж болно.

CCER-ийн зээлийн нөхөн төлбөрийн хэмжээ нь үндэсний ЭЕШ-ын зорилтоос давсан ялгаралтын 5 хувиар хязгаарлагддаг. CCER-ийн өмнөх төлөвлөгөөг арилжааны хэмжээ бага, нүүрстөрөгчийн хийн аудитад стандарт байхгүйн улмаас 2017 онд цуцалсан. Хятад улс өнгөрсөн оны 7 дугаар сард өөрийн үндэсний ETS-ээ нэвтрүүлснээс хойш CCER системийг сэргээх үзэл баримтлал олны анхаарлыг татсан. Үндэсний ETS-ийг удирддаг Шанхайн Байгаль орчин, эрчим хүчний биржийн дарга Лай Сяомин нэгдүгээр сард өгсөн ярилцлагадаа засгийн газар CCER-ийг 2022 онд дахин эхлүүлэхээр идэвхтэй төлөвлөж байгаа гэж мэдэгджээ.

Refinitiv-ийн шинжээч Лин Юан CCER-ийг дахин нэвтрүүлснээр нөхөн төлбөрийн эрэлт нэмэгдэж, CCER-ийн нийлүүлэлтийн хэмжээ 300 сая тонноос дээш байх магадлалтай.

Дотоодын болон гадаадын байгууллага, компани, олон нийт, хувь хүмүүс сайн дурын үндсэн дээр утааг бууруулах гүйлгээнд оролцох эрхтэй. Цаашид Хонконгийн болон гадаадад төвтэй аж ахуйн нэгжүүд олон улсын шалгуурыг хангасан CCER-үүдийг нүүрсхүчлийн хийг нөхөх ерөнхий төлөвлөгөөнд оруулснаар CCER системд оролцох боломжтой болно гэж үзэж байна.

Карбон зах зээл дээр карбон кредитүүд арилжаалагдаж байгаа бол хөрөнгийн зах зээл дээр сүүлийн үед нүүрсхүчлийн хийг бага ялгаруулах үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцааг хөрөнгө оруулагчид эрэлхийлэх болсон. Нөгөө талаасаа технологи, уул уурхай, эрчим хүчний томоохон компаниуд тэг нүүрсхүчлийн хийн ялгаруулалт руу чиглэсэн үйл ажиллагааг явуулах боллоо.

Эх сурвалж: <https://carboncredits.com>




ФИНТЕК БА РЕГТЕК

ФИНТЕКИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2023 оны эхний хагас жилд инфляц болон зээлийн хүүгийн өсөлт, Орос, Украины мөргөлдөөн, үнийн өсөлт, АНУ дахь банкнуудын дампуурал зэрэг нь финтекийн салбарын хөрөнгө оруулалтад сөрөг нөлөө үзүүлж байна гэж мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс 2023 оны 7 дугаар сард нийтлэгдсэн “Pulse of Fintech” финтекийн салбарын тайланд дурджээ.

Тус сэтгүүлд дурдсанаар 2023 оны эхний хагас жилд дэлхий даяар нийт 52.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтаар 2,153 удаагийн хэлцэл хийгдсэн байна. Финтекийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ 2022 оны эхний хагас жилийн үзүүлэлттэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй харин логистик болон нийлүүлэлтийн сүлжээ, ESG-д төвлөрсөн финтекийн хөрөнгө оруулалт өмнөх жилийн нийт дүнгээс харьцангуй өссөн үзүүлэлттэй байна.

Зураг. Дэлхийн финтекийн салбарын хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG


2023 оны эхний хагас жилд дэлхийн хэмжээнд 1.0 тэрбум ам.доллараас дээш дүнтэй 7 хэлцэл хийгдсэний 5 нь АНУ-д хийгдсэн бөгөөд тус улсад хийгдсэн нийт хэлцлийн дүн 34.9 тэрбум ам.доллар болсон нь дэлхийн нийт хөрөнгө оруулалтын гуравны хоёр хувийг эзэлж байгаа юм. Үүнээс хамгийн томоохныг дурдвал, Софра компани 8.0 тэрбум ам.доллараар Thomas Bravo-г худалдан авсан бол Stripe компани 6.8 тэрбум ам.долларын венчур капиталын хөрөнгө оруулалт татсан, Global Payments компани нь төлбөрийн үйлчилгээний финтек компани болох EVO-г 4.0 тэрбум ам.доллараар

худалдан авчээ. Европ, Ойрх Дорнод, Африкийн бүс нутаг болон Ази номхон далайн орнуудын бүс нутагт 1.0 тэрбум ам.доллараас дээш дүнтэй тус бүр нэг хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд Их Британид төвтэй эрчим хүчний мэдээллийн платформ бүхий компани болох Wood Mackenzie нь Veritas Capital-ийг 3.1 тэрбум доллароор худалдаж авсан бол Хятад улсад төвтэй Chongqing Ant Consumer Finance компани 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан үзүүлэлттэй байна.


2023 оны эхний хагас жилийн финтекийн салбарын төлөв байдлыг харахад дараах онцлогууд ажиглагдаж байна.

- ◆ Финтекийн салбарт шинээр хөрөнгө оруулалт хийхээс илүүтэйгээр өнөөгийн финтекийн үйл ажиллагааны тогтвортой байдал, үр ашигт илүү анхаарал хандуулж байна.
- ◆ Олон улсын хэмжээнд тухайн салбарт үүсэж байгаа хүндрэлүүдээс шалтгаалан криптовалют болон крипто биржийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, блокчейн шийдлүүдэд илүү анхаарал хандуулж байна.
- ◆ Төлбөр тооцооны финтек болон түүний дэд бүтцэд хийх хөрөнгө оруулалт нэмэгдсэн.
- ◆ Хиймэл оюун ухаан, ялангуяа кибер аюулгүй байдал, даатгалын технологи, wealthtech зэрэгт хөрөнгө оруулагчдын сонирхол давамгайлж байна.

Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь VC /venture capital/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцэл




Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь M&A /merge and acquisition/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь PE /private equity/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

ашиг авчрах тухайн цаг үедээ хамгийн хэрэгцээтэй финтекүүдэд хөрөнгө оруулалт хийх сонирхол өндөр байна.

- ◆ Төлбөр тооцооны финтек үйлчилгээний өрсөлдөөн нэмэгдэж тухайн төрөл нь зах зээлд давамгайлах байр суурийг эзэлж байна.
- ◆ Байгууллагууд үйл ажиллагаандаа хиймэл оюун ухааныг ашиглах, хөгжүүлэх нь улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэхүү хэрэгцээг дагаад хиймэл оюун ухаан хөгжүүлэлт нэмэгдэх хандлагатай байна.
- ◆ Улс орнууд криптовалютын зохицуулалтаа чангатгасаар байгаагийн улмаас тухайн салбарын хөрөнгө оруулалт зогсонги байдалд ороод байгаа бөгөөд харин ESG болон тогтвортой байдалд нийцсэн шийдлүүд болох нүүрстөрөгчийн зээл, уур амьсгалын токен шийдэл зэрэгт крипто санхүүжилт нэмэгдэх хандлагатай байна.

2023 оны финтекийн салбарын чиг хандлага, онцлог дараах нөхцөл, байдалтай харагдаж байна. Үүнд:

- ◆ Финтекийн хөрөнгө оруулагчид технологийн дэвшил хурдацтай хөгжиж байгаа энэхүү цаг үед богино хугацаанд

2023 оны эхний хагас жилд хөрөнгө оруулагчид макро эдийн засгийн сорилтууд, геополитикийн хурцадмал байдал, үнийн өсөлт зэрэг хүчин зүйлүүдээс үүдэн томоохон хөрөнгө оруулалт хийхээс болгоомжилсон тул финтекийн салбарын үзүүлэлтүүд багасахад нөлөөлсөн бөгөөд энэхүү нөхцөл байдал нь энэ оныг дуустал үргэлжлэх төлөвтэй байна гэж KPMG-ээс үзжээ.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ББСБ–ЫН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГА

/ӨМНӨХ ДУГААРЫН ҮРГЭЛЖЛЭЛ/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт П.Байгалмаа

БУСАД ОРНЫ ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА

Улс орнуудад мөрдөж буй эрх зүйн зохицуулалт

Сонгон судалсан улс орнуудад ББСБ–ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зохицуулдаг эрх бүхий байгууллага болон эрх зүйн актуудтай танилцъя.

Америкийн Нэгдсэн Улс /АНУ/ – АНУ–д мөнгө шилжүүлэгч, төлбөр төлөх болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх зэрэг нь холбооны болон муж улсын хуулиар зохицуулагддаг.

Холбооны түвшинд гол зохицуулагч нь АНУ–ын Сангийн яамны нэг хэсэг болох Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (Financial Crimes Enforcement Network (FinCEN)) юм.

FinCEN нь Банкны нууцын тухай хууль болон холбогдох мөнгө угаахтай тэмцэх зохицуулалтыг мөрддөг бөгөөд энэ нь ББСБ–аас мөнгө угаах хөтөлбөрийг баталж, хөтлөх, сэжигтэй үйл ажиллагааны тайлан гаргах, харилцагчийн зохих шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.

FinCEN–ээс гадна мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудыг хянадаг холбооны бусад зохицуулагч байгууллагууд нь Хэрэглэгчийн санхүүгийн хамгаалах товчоо (Consumer financial protection bureau (CFPB)), Валютын хяналтын алба, Холбооны хадгаламжийн даатгалын корпорац (FDIC) зэрэг орно.

Мужийн түвшинд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–ууд нь Нью–Йорк мужийн Санхүүгийн үйлчилгээний газар, муж улсын санхүүгийн зохицуулах агентлагаас тусгай зөвшөөрөл авч, зохицуулалтад хамрагдах бөгөөд тус зохицуулагч байгууллагаас мөнгөн гуйвуулга гүйцэтгэхэд тавих дүрэм, шаардлага тавьдаг.

Эдгээр хууль тогтоомжоос гадна мэдээллийн нууцлалын тухай хууль тогтоомж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, гэрээний тухай хууль зэрэг ББСБ–уудын анхаарах ёстой хууль эрх зүйн актууд бий.

Энэтхэг улс – Энэтхэг улсад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–уудын зохицуулалтын тогтолцоо байдаг. ББСБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг дүрэм, хэрэглэгчийн эрхийг хамгаалах журам, мэдээлэл хамгаалах дүрмийг дагаж мөрдөнө.

Харин хил дамнасан мөнгөн гуйвуулга эрхэлдэг ББСБ нь Гадаад валютын удирдлагын тухай хууль болон Энэтхэгийн үнэт цаас, биржийн зөвлөлөөс гаргасан дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллана.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–ууд зөвшөөрөл авна.

Энэтхэгт мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудын зохицуулалтыг 2007 онд баталсан Төлбөр тооцооны системийн тухай хуулийн дагуу мөнгөн гуйвуулгын системийн аюулгүй байдал, найдвартай байдал, тогтвортой байдлыг хангуулахаар Энэтхэгийн нөөцийн банк (Reserve Bank of India (RBI)) хянадаг. Үүнд:

- ◆ **Үйлчлүүлэгчээ таньж мэдэх хэм хэмжээ:** ББСБ нь үйлчлүүлэгчээ таньж мэдэх удирдамжийн дагуу үйлчлүүлэгчдийнхээ хувийн мэдээлэл, хаяг баталгаажуулах шаардлагатай.
- ◆ **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ:** ББСБ–ууд МУТСТ хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг томилох, сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн тагнуулын байгууллагад мэдээлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.
- ◆ **Өөрийн хөрөнгийн хүрэлцээнд тавигдах шаардлага:** Мөнгө гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ нь санхүүгийн тогтвортой байдлаа хангахын тулд өөрийн

хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээг хангаж ажиллах ёстой.

- ◆ **Технологи, аюулгүй байдлын стандартууд:** ББСБ нь харилцагчдынхаа гүйлгээний аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд зохих технологи, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.
- ◆ **Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизм:** ББСБ нь үйлчлүүлэгчдийн гомдлыг шийдвэрлэх, шуурхай шийдвэрлэхийн тулд гомдол барагдуулах механизмтай байх ёстой.

Филиппин улс – Филиппин улсад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ тусгай зөвшөөрөл авах ба тэдгээрийн харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулдаг.

- » 1993 онд батлагдсан Төв банкны тухай хууль (Бүгд найрамдах улсын хууль №7653) – Энэ хуулиар Филиппиний мөнгөний төв байгууллага болох Бангро сентрал нг пилипинас (Bangko Sentral ng Pilipinas (BSP)) нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудыг зохицуулах үүрэгтэй.
- » 2000 онд батлагдсан Банкны ерөнхий хууль (Бүгд найрамдах улсын №8791 дүгээр хууль) Энэ хууль нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–д тавигдах шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна. Энэ хуулийн дагуу ББСБ мөнгө гуйвуулгын үйлчилгээ эрхлэхийн тулд тусгай зөвшөөрөл авах ёстой.
- » 2001 онд батлагдсан Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (Бүгд найрамдах улсын хууль №9160) –аар Филиппиний санхүүгийн системийг мөнгө угаах үйл ажиллагаанд ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Энэ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–ыг харилцагчийг таних, баталгаажуулах журмыг дагаж мөрдөх, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх, гүйлгээний бүртгэл хөтлөхийг шаарддаг.
- » Валютын журам (BSP Circular №1041) – Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг тусгасан. Үүнд лиценз, капиталжуулалт, тайлагналын шаардлага, эрсдэлийн удирдлага гэх мэт хамруулсан.

Мөн ББСБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг дүрэм, хэрэглэгчийн эрхийг хамгаалах журам, мэдээлэл хамгаалах дүрмийг тус тус дагаж мөрдөнө.

Мексик улс – Мексик улс дахь цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч ББСБ–ын үйл ажиллагаа нь 2018 оны 9 дүгээр сарын 10–ны өдөр хүчин төгөлдөр болсон Мексикийн Санхүүгийн технологийн байгууллагын тухай хууль (Ley de Instituciones de Tecnología Financiera буюу Финтекийн тухай хууль)–аар зохицуулагддаг.

Уг хуулийн дагуу ББСБ нь санхүүгийн үйл ажиллагаа явуулахын тулд Үндэсний банк, үнэт цаасны хороо (Comisión Nacional Bancaria y de Valores буюу “CNBV”)–оос зөвшөөрөл авах ёстой. Мөн капиталжуулалт, засаглал, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой зохицуулалтын янз бүрийн шаардлагыг дагаж мөрдөнө.

Мексик улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь дээр дурдсан хуулиас гадна дараах эрх зүйн актыг дагаж мөрдөх ёстой.

- » Мексик дэх гадаад валютын гүйлгээ, гадаад валют худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохицуулдаг Валютын тухай хууль (Ley del Mercado de Valores).
- » Мөнгө угаахын эсрэг хууль (Ley Anti-Lavado de Dinero). Энэ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг тогтоодог.
- » Мексикийн төлбөрийн системийг зохицуулдаг Төлбөрийн системийн тухай хууль (Ley de Sistemas de Pagos) бөгөөд уг хуулиар ББСБ–уудыг төлбөрийн системийн операторын гишүүн байхыг шаарддаг.
- » Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (Ley Federal de Protección al Consumidor) нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг бий болгож, ББСБ–аас үйлчилгээ, төлбөрийн талаар тодорхой, ил тод мэдээлэл өгөхийг шаарддаг.

Мексик дэх ББСБ–ууд мөн эдгээр зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөхийн тулд CNBV–ийн байнгын хяналт дор үйл ажиллагаа эрхэлнэ.

Дээр дурдсан улс орнуудад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–уудын харилцааг зохицуулах тогтолцоо нь өөр өөр байдаг ч нийтлэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах журам, мэдээлэл хамгаалах журам зэрэг олон зохицуулалтууд нь ижил төстэй байна. ББСБ нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангаагүй, санхүүгийн зах зээл, өөрийн байгууллагын болон харилцагчийн нэр хүндэд хохирол учруулахгүйн тулд үйл ажиллагаа явуулж

буй нутаг дэвсгэр бүртээ зохицуулалтын шаардлагыг бүрэн дагаж мөрдөх ёстой.

Сонгон судалсан улс оронд үйлдэгдсэн мөнгөн гуйвуулгатай холбоотой сорил, шийдвэрлэлт

Сонгон судалсан улс орнуудад ББСБ-ууд мөнгө гуйвуулгатай холбоотой хэд хэдэн гэмт хэргийн тохиолдол гарсан. Жишээ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлснээр гэмт хэргийн шинжтэй үйлдэд холбогдсон туршлагаас энд дурдья.

Америкийн Нэгдсэн Улс:

Western Union: 2017 онд Western Union нь залилан мэхлэх, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадаагүйн улмаас АНУ-ын Хууль зүйн яам (DOJ) болон Холбооны Худалдааны Комисс (FTC)-ийн тооцоогоор 586 сая ам.доллар төлөх болсон. Тус компани нь залилан мэхлэгчдэд мөнгө гуйвуулгын үйлчилгээгээ ашиглан хэрэглэгчдийг залилан мэхлэхийг зөвшөөрч, хүн хууль бусаар хил давуулах болон бусад гэмт хэрэгтнүүдийг хууль бусаар мөнгө шилжүүлэх ажлыг хөнгөвчлөхийг зөвшөөрсөн гэдгээ хүлээн зөвшөөрсөн.

MoneyGram: АНУ-ын Хууль зүйн яам, 2012 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр, мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлээгүй, утсаар маркетингийн схемд мөнгө шилжүүлэх үйлчилгээгээ ашиглан хэрэглэгчдийг залилан мэхлэхийг зөвшөөрсөн гэм буруугаа хүлээсэн тул 100 сая ам.доллар төлөх арга хэмжээ авсан.

Liberty Reserve: 2013 онд мөнгө угаах болон бусад гэмт хэрэгт ашигладаг онлайн төлбөрийн системийг үүсгэн байгуулагчийг Испанид баривчилж, АНУ-д шилжүүлэн өгчээ. Тэрээр 250 сая ам.доллар угаасан хэргээ хүлээв. Тус компанийг мөнгө угаах, хувийн мэдээлэл хулгайлах, хар тамхины наймаа зэрэг хууль бус гүйлгээнд 6 тэрбум гаруй долларын гүйлгээ хийсэн гэж буруутгагдсан.

Энэтхэг улс:

Payworld: 2019 онд дижитал төлбөрийн платформ Payworld нь Энэтхэгийн гадаад валютын зохицуулалтыг зөрчин Энэтхэгээс Дубай руу зөвшөөрөлгүй хууль бус мөнгөн гуйвуулга үйлдэхэд тусалсан гэж буруутгагдсан. Тус компани буруутай үйлдлээ үгүйсгэж байгаа.

Vodafone M-Pesa: 2019 онд гар утасны мөнгө шилжүүлэх үйлчилгээ Vodafone M-Pesa-г Энэтхэгийн Нөөцийн банк (RBI) хэрэглэгчээ таних болон мөнгө угаахтай тэмцэх журам зөрчсөн гэж торгууль ногдуулсан. RBI нь Vodafone M-Pesa-ыг үйлчлүүлэгчийг зохих ёсоор шалгаж, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлээгүй

болохыг тогтоожээ. Тус компанийг 3.05 сая рупи (ойролцоогоор 410,000 ам.доллар)-р торгожээ.

Weizmann Forex: 2019 онд валютын болон мөнгө гуйвуулгын Weizmann Forex компанийг мөнгө угаахын эсрэг журмыг зөрчсөн гэж RBI торгууль ногдуулсан. Тус компани нь мөнгө угаахтай тэмцэх журмын зохих хяналтыг хэрэгжүүлж, үйлчлүүлэгчдэд зохих шалгалт хийж чадаагүй нь тогтоосон. RBI-аас Weizmann Forex-ийг 3 сая рупи (ойролцоогоор 400,000 доллар)-р торгосон.

Филиппин улс:

Филрем: 2016 онд мөнгө гуйвуулгын Philrem компани Бангладешийн банкаас хулгайлагдсан 81 сая ам.доллар угаасан хэрэгт холбогдсон. Уг хөрөнгийг Филрем зэрэг хэд хэдэн банк, мөнгөн гуйвуулгын компаниудаар дамжуулан Филиппин рүү шилжүүлж, дараа нь казиногоор дамжуулан угаасан байна. Филиппиний засгийн газар Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийг зөрчсөн Филрем компанийн эзэд болон удирдах ажилтнуудын эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн.

RCBC: Мөнгө угаах гэмт хэрэгт Филиппиний Ризал Арилжааны Банкны Корпорац (RCBC) мөн холбоотой байсан. RCBC-г Филиппиний төв банк хулгайлсан мөнгийг хууль бусаар шилжүүлэхээс сэргийлж чадаагүйн улмаас торгууль ногдуулжээ. Мөн RCBC-ийн хэд хэдэн удирдлагуудыг мөнгө угаасан, банкны хууль зөрчсөн хэргээр буруутгасан.

I-Remit: 2018 онд мөнгө гуйвуулгын I-Remit компанийг мөнгө угаахтай тэмцэх журмыг дагаж мөрдөөгүйн улмаас Филиппиний төв банк торгууль ногдуулсан. Төв банк I-Remit нь мөнгө угаахын эсрэг хяналт хангалтгүй, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлээгүй болохыг тогтоожээ. Тус компанийг 5 сая PHP (ойролцоогоор 100,000 доллар)-аар торгожээ.

Мексик улс:

Мексикт гарсан ББСБ-ын мөнгө гуйвуулгатай холбоотой гэмт хэрэг үйлдэл бол Вестерн Юнион /Western Union/ компани юм. 2018 онд Мексикийн засгийн газраас Вестерн Юнион мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгасан.

Мөрдөн байцаалтын явцад Вестерн Юнион нь хууль бус үйл ажиллагаа, тухайлбал утсаар залилан мэхлэх, мөнгө угаах зэрэг хууль бус үйлдлүүдэд тус дөхөм үзүүлж, агентууддаа зохих шалгалт хийлгүйгээр, сэжигтэй үйлдлүүдийг мэдээлэхгүйгээр гүйлгээ хийх боломжийг олгосон болохыг тогтоогдсон. Мөн Мексикийн эрх баригчид Вестерн Юнион нь мөнгө угаахын эсрэг зохих хяналт, бодлогыг хэрэгжүүлээгүйн улмаас тус агентууд

гэмт хэргийн байгууллагуудын гүйлгээг хөнгөвчлөхөд хүргэсэн болохыг тогтоожээ. Вестерн Юнион компанийг мөнгө угаах, утасны залилангаас урьдчилан сэргийлж чадаагүй гэж 60 сая ам.долларын торгууль ногдуулсан.

Дээр дурдсан хэргүүд мөнгөн гуйвуулгын салбарт хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд хэрэглэгчээ таниж мэдэх

болон мөнгө угаахын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхийн чухал болохыг онцолж, зөрчилтэй холбоотой эрсдэлүүдийг харуулж зөрчсөн тохиолдолд өндөр торгууль, хуулийн хариуцлага хүлээлтийг харуулж байна. Иймээс улс орны засгийн газар энэ салбарын зохицуулалтыг чангатгаж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг тогтмол авч байна.

МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ

Монгол Улсад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ-уудын харилцааг зохицуулах эрх зүйн тогтолцоо бүрдсэн гэж үзэж болно.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.22-т “мөнгөн гуйвуулга” гэж төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээг; гэж тодорхойлсон.

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтэд мэдээлдэг ББСБ-уудын 2023 оны I улирлын санхүүгийн тайлан нэгтгэлийн танилцуулгад тайлант онд санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 40 ББСБ байгаа нь өмнөх онтой харьцуулбал 2 ББСБ нэмэгдсэн байна.

Хүснэгт. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2022-I	2023-I	Тоо	Хувь
1	Нийт ББСБ-ын тоо	529	514	(15)	-2.8%
2	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	38	40	2	5.3%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эдгээр 40 ББСБ бүгд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг.

Хүснэгт. Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2021	2022	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Мөнгөн гуйвуулгын орлого	530,639.3	1,037,080.4	0.4%	506,441.1	95.4%

Өмнөх оны мөн үеэс өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд мөнгөн гуйвуулгын орлого 95.4 хувиар өсөж 1,037,080.4 сая төгрөгт хүрчээ.

Хүснэгт. Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгөн гуйвуулгын орлого	1,037.1	919.4	816.7	220.4	-	1,037.1	-	220.4	-

2023 оны I улирлын байдлаар 18 ББСБ 48.8 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 7 ББСБ 4.8 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Энэ нь Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг нэмэгдэхийн хэрээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь нэмэгддэг гэсэн үг юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх буй 2021 онд 36 ББСБ-ын 2-т, 2022 онд 37 ББСБ-ын 14 ББСБ-т итгэлцлийн үйлчилгээ, банк, санхүүгийн байгууллага, төслийн зээлийн санхүүжилт, өрийн бичгээр эх үүсвэр болон валют арилжаа, мөнгө угаах терроризмыг санхүүжүүл хуулийн хэрэгжилт зэрэг хэсэгчилсэн шалгалт гүйцэтгэсэн байна.

2022 онд Санхүүгийн зохицуулах хороонд ББСБ-ын үйл ажиллагааны талаар иргэд, аж ахуйн нэгжээс нийт 99 өргөдөл гомдол ирснээс мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг нэр бүхий 11 ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой давхардсан тоогоор 21 өргөдөл гомдол байна. Үүнд мөнгөн гуйвуулгатай холбоотой 1 өргөдөл байгаа нь шилжиж ирсэн мөнгөө еврогоор нь авах хүсэлт болно.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2021, 2022 онуудад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-дын мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд тусгайлсан шалгалт бол хийгээгүй байна.

Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn сайтаас Эрүүгийн хуулийн хуулийн 26.1 “Кибер орчинд хууль бусаар халдах”, 26.2 “Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник

хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах”-р зүйлээр зүйлчилж шийдвэрлэсэн, анхан шатны шүүхийн хүчинтэй шийтгэх тогтоолуудыг шүүж үзэхэд шүүхийн нийт 20 шийдвэрийг нээлттэй байршуулжээ. Үүнд:

- ◆ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ял шийтгэсэн шүүхийн 1 шийдвэр;
- ◆ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ял шийтгэсэн шүүхийн 2 шийдвэр;
- ◆ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйл болон 17.1 дүгээр зүйл-Хулгайлах гэмт хэрэгт давхар ял шийтгэсэн шүүхийн 4 шийдвэр;
- ◆ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйл болон 17.3 дугаар зүйл-Залилах гэмт хэрэгт давхар ял шийтгэсэн шүүхийн 8 шийдвэр;
- ◆ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлд зааснаар болон бусад гэмт хэрэгт давхар ял шийтгэсэн шүүхийн 3 шийдвэр

Дээрх мэдээллээс харвал Эрүүгийн хуулийн 26.1-д заасан гэмт хэргийг хулгайлах, цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэгтэй давхар зүйлчилж шийдвэрлэсэн нь түгээмэл байна.

Харин цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ-дад үр дүнтэй байнгын хяналт тавих нь санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хангах, хэрэглэгчдийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Энэхүү байнгын хяналт нь аливаа асуудлыг томоохон асуудал болохоос нь өмнө илрүүлж, шийдвэрлэхэд туслах бөгөөд ББСБ-ын үйл ажиллагааг аюулгүй, ил тод байлгах, санхүүгийн системийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахад чиглэгдэнэ.

Хяналт нь ихэвчлэн ББСБ-ын мөнгөн гуйвуулгын харилцааг зохицуулах холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэх, эрсдэл тодорхойлох, удирдах, үүссэн аливаа маргаан, гомдлыг шийдвэрлэж байгаа зэрэг асуудлууд багтана.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ-дад тавих хяналтыг тухайн ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй тухайн улсын холбогдох төрийн зохицуулагч байгууллага гүйцэтгэдэг.

Зохицуулагч байгууллага нь ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт шалгалт хийх, зайнаас үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, баримт бичигтэй танилцах зэрэг байнгын хяналт тавьж ажилладаг.

Зохицуулагч байгууллага нь ББСБ-ийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэх, эрсдэлийг удирдах хяналтын тогтолцоо, мөнгө угаах болон терроризмтой тэмцэх журам, харилцагчийн хяналт шалгалтын журам, гүйлгээний хяналтын систем зэргийг үнэлж болно.

Мөн ББСБ-ын хууль бус үйл ажиллагааг илрүүлж, шийдвэрлэхийн тулд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ-дад тавих хяналтад хууль сахиулах байгууллага зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, зохицуулалт хийж болно.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ-ын үзүүлж буй мөнгөн гуйвуулгын үйлчилгээг улс орон, харьяаллаас хамаарч зохицуулалт нь өөр өөр байж болох ч ерөнхийдөө дараах нийтлэг шинжтэй байна. Үүнд:

◆ **Зохицуулалтын нийцэл** – ББСБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон санхүүгийн үйлчилгээ, мөнгөн гуйвуулгатай холбоотой бүхий л холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой. Эдгээр журамд

үйлчлүүлэгчийг таних, баталгаажуулах, гүйлгээг хянах, сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх зэрэг багтана. ББСБ-ын үйл ажиллагаанд тавигддаг зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөөгүй тохиолдолд торгууль болон бусад холбогдох захиргааны шийтгэл ногдуулдаг.

◆ **Лиценз ба бүртгэл** – Олон оронд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь тусгай зөвшөөрөл авах эсвэл холбогдох зохицуулах байгууллагад бүртгүүлэх шаардлагатай. Уг эрх мэдэлд төв банк, санхүүгийн зохицуулах байгууллага эсвэл бусад төрийн байгууллагууд багтаж болно.

◆ **Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь үйлчилгээнийхээ хураамж, валютын ханш болон бусад нөхцөл, болзлыг ил тод болгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийг дагаж мөрдөх ёстой. ББСБ-аас гүйлгээтэй холбоотой асуудалтай тулгарсан харилцагчдад буцаан олголт эсвэл нөхөн төлбөр олгохыг шаардаж болно.

◆ **Мэдээллийн нууцлал** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь хэрэглэгчийн мэдээллийг найдвартай, нууцлалтай байлгах үүднээс мэдээллийн хамгаалалт, нууцлалын хуулийг чанд дагаж мөрдөх ёстой.

◆ **Гэрээний үүрэг** – ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь ББСБ болон мөнгө илгээгч, хүлээн авагчийн хооронд байгуулсан гэрээ байж болно. Эдгээр гэрээний нөхцөл, болзол нь хууль ёсны дагуу хүчин төгөлдөр байх ёстой. Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүсэх маргаан шийдвэрлэх үйл явц нь тухайн ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй харьяалал, тухайн гүйлгээний тодорхой нөхцөл, ББСБ болон түүний харилцагчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөлөөс хамаарна. ББСБ-ууд маргаанаас зайлсхийх болон шийдвэрлэхэд чухал алхам бол холбогдох зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөж, гэрээний нөхцөлүүд нь тодорхой, биелэгдэхээр байх явдал юм. ББСБ-ын маргааны шийдвэрлэлтийн нийтлэг байдлыг авч үзвэл:

» **Холбогдох хууль** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зохицуулах холбогдох хууль тогтоомж нь ББСБ болон түүний харилцагчдын харьяаллаас хамаарч өөр өөр байж болно. Ихэнх тохиолдолд ББСБ-ын бүртгэлтэй

эсвэл үндсэн үйл ажиллагаа явуулдаг харьяаллын хууль үйлчилнэ. Мөн ББСБ болон харилцагчийн хооронд байгуулсан гэрээнд холбогдох хуулийг зааж өгч болно.

- » **Маргаан шийдвэрлэх харьяалал** – ББСБ болон түүний харилцагчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөлөөс хамааран маргаан хянан шийдвэрлэнэ. Ихэнх тохиолдолд гэрээнд тодорхой шүүх, арбитр гэх мэт маргааныг шийдвэрлэх харьяаллыг зааж өгч болно. Эсвэл ББСБ-ын бүртгэлтэй буюу үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг харьяаллынх нь дагуу маргаан хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоож болно.
 - » **Арбитр** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний олон гэрээнд арбитрын заалтууд багтдаг бөгөөд маргааныг шүүхээр бус арбитрын шүүхээр шийдвэрлэхийг шаарддаг. Энэ нь маргааныг шийдвэрлэх илүү үр ашигтай, зардал багатай арга замыг бий болгож болно.
 - » **Зуучлах** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний гэрээнд маргааныг зуучлагчаар дамжуулан шийдвэрлэх шаардлагатай зуучлалын заалтууд багтаж болно. Эвлэрүүлэн зуучлах нь маргааныг шийдвэрлэхэд бага зэрэг зөрчилдөөнтэй, илүү хамтран ажиллах боломжийг олгодог.
 - » **Зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнд гомдлыг шийдвэрлэх үйл явц, тухайлбал, томилсон гомдол хариуцсан ажилтантай байх ба тэрээр үйлчлүүлэгчийн гаргасан гомдлыг хянах, гомдол шийдвэрлэх үйл явцад хамаарах алхмуудыг зааж, мэдээлэл өгөх зэрэг шаардлагууд багтаж болно.
 - ◆ **Хил дамнансан зохицуулалт** – Хил дамнансан гүйлгээг хамарсан цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад валют болон татварын зохицуулалт, орон нутгийн хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
 - ◆ **Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тавих** – Зохицуулагч байгууллага цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ-д зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоож болно. Энэхүү зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нь ББСБ-ын санхүүгийн тогтвортой байдал, тогтвортой байдлыг үнэлэх, үйл ажиллагаагаа аюулгүй, найдвартай эрхлэхэд ашигладаг санхүүгийн хэмжүүр болно.
 - Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэмжээ нь харьяалал болон зохицуулах байгууллагаас хамаарч өөр өөр байж болно. Гэсэн хэдий ч хэрэглэж болох нийтлэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг энд дурдъя. Үүнд:
 - » **Хөрөнгийн хүрэлцээний харьцаа (Capital Adequacy Ratio (CAR))** – Энэ нь ББСБ-ын алдагдлыг шингээх чадварыг илэрхийлдэг үзүүлэлт юм. ББСБ-ын дүрмийн санг эрсдэлд тооцсон хөрөнгөнд нь хувааж тооцдог. CAR өндөр байх тусам ББСБ нь санхүүгийн хувьд илүү найдвартай гэж үзэж болно.
 - » **Хөрвөх чадварын харьцаа (Liquidity Ratio)** – Энэ нь ББСБ-ын богино хугацаанд үүргээ биелүүлэх чадварыг хэмждэг. ББСБ-ын хөрвөх чадвартай хөрөнгийг богино хугацаат өр төлбөрт нь хувааж тооцдог. Хөрвөх чадварын харьцаа өндөр байх нь ББСБ үүргээ биелүүлэх чадвартайг харуулна.
 - » **Хөшүүргийн харьцаа (Leverage Ratio)** – Энэ нь ББСБ-ын өөрийн хөрөнгөтэй харьцуулахад эрсдэлд өртөх нийт хэмжээг хэмждэг. ББСБ-ын нийт хөрөнгийг өөрийн хөрөнгөд хуваах замаар тооцно. Хөшүүргийн харьцаа бага байх тусам ББСБ-ыг санхүүгийн хувьд илүү найдвартай гэж үзнэ.
 - » **Хөрөнгийн чанарын харьцаа (Asset Quality Ratio)** – Энэ нь ББСБ-ын хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг удирдах, хянах чадварыг хэмждэг. ББСБ-ын чанаргүй зээлийг нийт зээлд нь хувааж тооцдог. Энэ харьцаа бага байх тусам ББСБ-ын хөрөнгийн чанар сайжирна.
 - ◆ **Зохицуулалтын тайлан, хяналт** – ББСБ-ууд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтээ ханган ажиллаж байгаа эсэхэд зохицуулагч байгууллагууд байнгын хяналт тавьж, шалгалт хийх бөгөөд ББСБ нь үйл жиллагааны болон санхүүгийн тайлан мэдээгээ зохицуулагч байгууллагад тогтмол хүргүүлж, аудит хийлгэх ёстой.
- Ерөнхийдөө цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь хэрэглэгчдийг хамгаалах, санхүүгийн системийн нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүйн хүрээнд ажиллах ёстой.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дүгнэж хэлэхэд, ББСБ–аас үзүүлж буй хувь хүн, аж ахуйн нэгжээс нөгөөд мөнгө шилжүүлэх цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ дэлхий даяар улам бүр түгээмэл болж, мөнгө шилжүүлэх ажлыг хялбар, зардал бага, хурдан хийх боломжтой болж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5–р зүйлийн 5.1.22–т “мөнгөн гуйвуулга” гэж төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээг; гэж тодорхойлсноор төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ хийгддэг тул бусад санхүүгийн үйл ажиллагаанаас ялгаатай.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь улс орон бүрд харилцан адилгүй боловч ихэвчлэн цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан, харилцагчаа таньж мэдэх, мөнгө угаахтай тэмцэх журам, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, мэдээлэл хамгаалах хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Эдгээр журмыг дагаж мөрдөх нь хүндрэлтэй байж болох ч ББСБ–ууд харилцагчидтайгаа итгэлцлийг бий болгох, хурдацтай хөгжиж буй цахим мөнгөн гуйвуулгын салбарт өрсөлдөх давуу талыг хадгалахад нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Харин зохицуулагч байгууллагууд дээрх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, цахим мөнгөн гуйвуулгын салбарын аюулгүй, ил тод үйл ажиллагааг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэхүү судалгаандаа ББСБ–ын хувьд цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалттай холбоотой олон талын асуудлыг хөндсөн болно.

Судалгаа маань цахим мөнгөн гуйвуулгын тухай ойлголт, үйл явцад оролцож буй оролцогчид, цахим мөнгөн гуйвуулгын ангилал, төрлүүдийн талаар эхэлсэн. Дараа нь холбогдох хууль тогтоомж, маргаан шийдвэрлэх үйл явцыг багтаасан олон улсын жишиг хууль тогтоомж, мөнгөн гуйвуулгын эрх зүйн онцлог, хяналт зохицуулалтыг судлав. Үүний дараа АНУ, Энэтхэг, Филиппин, Их Британи, Мексик, Монгол зэрэг улс орнуудын цахим мөнгөн

гуйвуулгын эрх зүйн зохицуулалт, сорилт хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгасан.

Түүнчлэн судалгаанд ББСБ–ын хэвийн үйл ажиллагааг хангах зохистой харьцааны талаар дурдлаа.

Цахим мөнгөн гуйвуулгын салбарт ББСБ чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйл явцыг хөнгөвчлөх төрөл бүрийн үйлчилгээ үзүүлж байна.

ББСБ–уудад хэрэглэгчийн тав тух, хүртээмжтэй байх хэрэгцээ, аюулгүй байдал, дагаж мөрдөх шаардлагыг тэнцвэржүүлэх байдлыг хангахад салбарын хууль эрх зүйн чухал нөлөө үзүүлдэг.

Дэлхийн банк, ОУВС, ФАТФ зэрэг олон улсын байгууллагууд мөнгөн гуйвуулгын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой хууль эрх зүйн нийтлэг асуудалд залилан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг орно. Зарим улс орон хатуу хуультай, зарим нь сул зохицуулалттай байдаг. ББСБ–ууд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж, хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтийг цаг тухайд нь хэрэгжүүлэх нь цаг үетэйгээ зэрэгцэн амжилттай үйл ажиллагаа явуулж, харилцагчдынхаа мөнгөн хөрөнгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Санал, зөвлөмж

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ улам бүр дэлгэрэх өнөө үед зохицуулагч байгууллагын зүгээс тус үйлчилгээ үзүүлэгч ББСБ–д хийх хяналт, зохицуулалтыг эрчимжүүлэх, ББСБ–уудыг эрхлэх үйл ажиллагаанаас нь хамааруулж үйл ажиллагаанд тавих зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ялгаатай тооцох, байнгын хяналтыг сайжруулах, бодит цагийн хяналтыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороо сар бүр зохицуулалттай этгээдээс авдаг цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайлан хэт ерөнхий мэдээлэл агуулж байгаа учир мэдээллийн цар хүрээг өргөтгөх нь зүйтэй.

ЭХ ҮҮСВЭР

- ◆ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
- ◆ Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль
- ◆ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- ◆ Үндэсний төлбөрийн системийн тухай хууль
- ◆ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
- ◆ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- ◆ Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- ◆ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам
- ◆ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам
- ◆ Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
- ◆ Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам
- ◆ Цахим мөнгөний журам Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- ◆ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам
- ◆ Deloitte, "Digital Remittances: A New Era of Growth for Non-Bank Financial Institutions," 2019
- ◆ Asian Development Bank, "Digital Financial Services for Remittances: The Role of Non-Bank Financial Institutions," 2020
- ◆ World Bank Group, "Digital Financial Services for Remittances: Opportunities and Challenges for Non-Bank Financial Institutions," 2019,
- ◆ International Finance Corporation, "Digital Financial Services for Remittances: A Guide for Non-Bank Financial Institutions," 2019,
- ◆ Financial Action Task Force (FATF). (2019). Guidance for a risk-based approach to virtual assets and virtual asset service providers.
- ◆ International Organization for Migration (IOM). (2019). Regulatory challenges facing the remittance industry: A global perspective. Retrieved from
- ◆ World Bank. (2019). Remittance prices worldwide

ИНСУРТЕК ГЭЖ ЮУ ВЭ?



Инсуртек гэдэг нь даатгал болон технологи гэсэн үгнүүдийн хослолоос бүрдсэн нэршил бөгөөд технологид суурилсан даатгалын үйлчилгээг инсуртек гэж нэрлэнэ.

ИНСУРТЕКИЙН САЛБАРЫН ГОЛЛОХ ТРЕНД

**Дижитал хэрэглэгчийн үйлчилгээ:**

Технологийн дэвшил нь хэрэглэгчид даатгалын үйлчилгээг худалдан авах, нөхөн төлбөр нэхэмжлэх зэрэг бүхий л харилцааг цахимаар гүйцэтгэх боломжийг олгож байна.

**Блокчэйд суурилсан аюулгүй байдлын баталгаажуулалт:**

Даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн нэхэмжлэл, гүйлгээг блокчэйн дээр аюулгүй, ил тодоор гүйцэтгэн, хадгалах боломжтой.

**Эрсдэлийн үнэлгээ:**

Ахисан түвшний өгөгдлийн шинжилгээ, их өгөгдөл, хиймэл оюун ухааны тусламжтайгаар даатгалын эрсдэлийг илүү тодорхой үнэлэх боломж бүрдсэн.

**Чатбот болон хиймэл оюун ухааны туслах:**

Хиймэл оюун ухаанд суурилсан чатботууд нь хэрэглэгчид 24/7 горимоор тусламж үзүүлэн, шаардлагатай асуултад нь хариулна.

**Телематикс болон юмсын интернэт:**

Тээврийн хэрэгсэл болон бусад төрлийн өргөн хэрэглээний төхөөрөмж дэх зайнаас мэдээлэх төхөөрөмжийн тусламжтайгаар бодит цагийн горимоор өгөгдлийг цуглуулах боломж бүрдэж буй бөгөөд ингэснээр хэрэглэгч тухай бүрд тохирсон даатгалын бүтээгдэхүүнийг санал болгох боломжтой.

**P2P даатгал:**

Инсуртек нь заавал хэн нэгэн даатгагчид хандалгүйгээр хэрэглэгчид өөрсдөө бүлэг үүсгэн эрсдэлээ тархах байдлаар нэг нэгнийгээ даатгах боломжийг бүрдүүлж байна.

**Нөхөн төлбөрийн автоматжуулалт:**

Автоматжуулалт нь нөхөн төлбөр нэхэмжлэх процессыг түргэсгэн, бичиг цаасны ажлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх боломжийг олгож байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



Инсуртекийн зах зээл 2022 онд 5.48 тэрбум ам.доллаар хэмжигдэж буй бөгөөд 2030 он гэхэд тус зах зээлийн хэмжээ 146.43 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн тооцоолол байна.



Сонирхуулахад 2017 онд **"Лемонадь"** даатгалын компаний **хиймэл оюун ухаан болон чатботын хослол бүхий инсуртөкийн үйлчилгээ** даатгуулагчийн нөхөн төлбөрийг ердөө **ГУРВАН** секундйн дотор шийдвэрлэж даатгалын салбарт рекорд тогтоож байжээ.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ФИТЧ АГЕНТЛАГ АНУ-ЫН УРТ ХУГАЦААНЫ ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ “AA+” БОЛГОН БУУРУУЛЛАА.



2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Олон улсын үнэлгээний Fitch Ratings агентлагаас АНУ-ын урт хугацааны зээлжих зэрэглэлийг “AAA” түвшнээс нэг шатлалаар бууруулж “AA+” түвшинд болголоо. Зээлжих зэрэглэлийг бууруулах болсон гол шалтгаан нь АНУ-ын санхүүгийн салбарын ирэх гурван жилийн хугацаанд засгийн газрын өрийн дарамт өндөр хэвээр байхаас шалтгаалан муудах магадлалтай гэж үзсэнтэй холбоотой гэж тайлбарлажээ.

Эх сурвалж: www.fitchratings.com

ВЬЕТНАМЫН ЦАХИЛГААН АВТОМАШИН ҮЙЛДВЭРЛЭГЧ “VINFAST” КОМПАНИ NASDAQ БИРЖИД АНХНЫ АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ.



Вьетнамын цахилгаан автомашин үйлдвэрлэгч VinFast компани нь Nasdaq биржид нээлттэй компани болов. Нээлттэй компани

болсон эхний өдрөө компанийн хувьцааны үнэ 255%-иар өсч, зах зээлийн үнэлгээ нь 85 тэрбум доллароос давсан байна.

Ингэснээр “VinFast” компанийн зах зээлийн үнэлгээ Форд болон General Motors зэрэг дэлхийд тэргүүлэгч автомашин үйлдвэрлэгч компаниудыг зах зээлийн үнэлгээгээрээ тэргүүлэв.

Эх сурвалж: www.bloomberg.com

“JPMORGAN CHASE”-ИЙН ШИНЖЭЭЧИД БНХАУ-ЫН ДНБ 2023 ОНД 6.4 ХУВИАР ӨСНӨ ТААМАГЛАЛАА 4.8 ХУВЬ БОЛГОН БУУРУУЛЛАА.



Хятадын ДНБ 2022 оны 4 дүгээр улиралд 2.9 хувиар, 2023 оны 1 дүгээр улиралд 4.5 хувиар тус тус өссөн нь цар тахлын дараа Хятадын эдийн засаг эрчимтэй сэргэж буйг харуулж байсан. Гэсэн хэдий ч энэ оны 8 дугаар сарын 25-ны өдөр Хятадын Төв Банк бодлогын хүүгээ 15 суурь нэгжээр бууруулж, 2.5 хувь болгох шийдвэрээ зарласан. Энэ нь 2020 оноос хойших хамгийн өндөр хувиар бодлогын хүүгээ бууруулах гэнэтийн шийдвэр болсон төдийгүй үл хөдлөх хөрөнгийн зах зээлд уналт үргэлжилж байгаа энэ үед шинжээчдийн зүгээс 2023 онд Хятадын эдийн засаг 4.8 хувиар, 2024 онд 4.2 хувиар тус тус өснө гэж таамаглаж байна.

Эх сурвалж: www.jpmorgan.com

АНГЛИЙН ТӨВБАНК ИНФЛЯЦТАЙ ТЭМЦЭХИЙН ТУЛД БОДЛОГЫН ХҮҮГЭЭ 5 ХУВЬ ХҮРТЭЛ ӨСГӨВ.



Английн төв банк энэ оны 6 дугаар сарын 22-ны өдөр бодлогын хүүгээ 50 суурь нэгжээр нэмэгдүүлсэн нь олон хөрөнгө оруулагчдыг гайхшируулав.

Төвбанкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүгээ 4.5 хувиас 5 хувь болгон өсгөсөн нь 2008 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм.

Англид эрчим хүчний үнийн өсөлт сүүлийн 31 жилийн дээд түвшинд хүрсэн төдийгүй инфляц 8 хувиас дээш өндөр түвшинд хадгалагдаж байгаа энэ үед Английн Төвбанк үргэлжлүүлэн бодлогын хүүгээ чангатгах төлөвтэй байна.

Эх сурвалж: www.reuters.com

2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД ЯПОНЫ ЭДИЙН ЗАСАГ 6 ХУВИАР ӨСЛӨӨ.



Японы эдийн засаг жилийн 6 хувиар өссөн нь Ройтерс агентлагийн санал асуулгаар 0.8 хувиар өснө гэж таамаглаж байснаас хамаагүй өндөр үзүүлэлт болж, 2022 оноос хойших хамгийн өндөр өсөлтийг үзүүлэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) түүхэн дээд хэмжээнд хүрлээ.

Энэ нь шинжээчдийн таамаглаж байснаас илүү хурдацтай өссөн үзүүлэлт бөгөөд энэхүү өсөлтөд автомашины экспорт хурдацтай явагдаж, жуулчид ихээр ирж байгаатай холбоотойгоор дотоодын хэрэглэгчдийн худалдан авалт сэргэж экспорт ихэссэн нь голлон нөлөөлжээ.

Эх сурвалж: www.reuters.com




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,404.33 -33.53 (-0.76%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


31,584.75 -182.07 (-0.57%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,356.88 -32.76 (-0.44%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,474.63 -156.42 (-1.15%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн Зохицуулах Хороо



@FRC_of_Mongolia